



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 01. 13 № 545. 134. 12 / 4206

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240101813 дугаартай тендерт оролцогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр /tender.gov.mn/ дамжуулан гаргасан тодруулгын хариут хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407036950

1. ТШЗ 19.2.1 заалтад заасан цахилгааны мэргэшсэн инженер, цахилгааны инженер, реле хамгаалалт автоматикийн инженер нь тендерт оролцогч компанийн үндсэн ажилтан байна гэсэн байгаа ийм төрлийн олон компани байхгүй байх. Энэ нь шударга өрсөлдөөний боломжийг хязгаарлаж байна гэж үзэж байгаа тул тус заалтыг өөрчилж өгнө үү.

Тодруулгын хариу

Зураг төсөлд үндэслэн БА-3.5, ТЗ -2.2, БА-6.3, БА-6.4 тусгай зөвшөөрлүүд шаардсан ба эдгээр тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд хүний нөөцөд тавигдах шаардлага боловсруулсан тул өөрчлөх боломжгүй.

2. Манай компани танай компаниас зарласан “Хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажил” төслийн ҮТӨҮГ/20240101813 дугаар бүхий Багц-1 болон Багц-2 тендерт оролцохоор материал бэлдэж байна. Манай компани дээрх тендерт дурьдсан хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх төслийн хүрээнд зарлагдсан ажлыг гүйцэтгэх бүрэн чадвар, боломжтой билээ. Гэвч дээрх тендерийн зарим технологийн өгөгдөл үзүүлэлт тодорхойгүй, барилга угсралтын хийгдэх ажлын хэмжээ тодорхойгүй тул бид тодорхой үнийн санал гаргаж өгөх боломжгүй байна. Иймээс тухайн тендерийн технологийн өгөгдөл үзүүлэлт, барилга угсралтын хийгдэх ажлын хэмжээ даалгаварыг бүрэн тодорхой болгохыг хүсэж байна.

Тодруулгын хариу

- ЭҮТӨҮГ/20240101813 дугаартай цахим тендерийн Багц №1-н технологийн үзүүлэлт мэдээллүүдийг доорх холбоосоор татаж авч танилцана уу

Холбогдох бичиг баримтууд

Тендерийн баримт бичиг Тодруулга ТЭЗҮ

БАРИМТ БИЧГИЙН НЭР	БАРИМТ БИЧИГ	ҮҮСГЭСЭН ОГНОО
ХӨТН техникийн даалгавар.pdf	ХӨТН техникийн даалгавар.pdf	

- ЭҮТӨҮГ/20240101813 дугаартай цахим тендерийн Багц №2-н барилга угсралтын ажлын хэмжээг доорх холбоосоор татаж авч танилцана уу

Холбогдох бичиг баримтууд

Тендерийн баримт бичиг Тодруулга ТЭЗҮ

БАРИМТ БИЧГИЙН НЭР	БАРИМТ БИЧИГ	ҮҮСГЭСЭН ОГНОО

SE29_Барилгын төсөв боть I stamped.pdf

[SE29_Барилгын төсөв боть I stamped.pdf](#)

SE29_Барилгын төсөв боть II stamped.pdf

[SE29_Барилгын төсөв боть II stamped.pdf](#)

SE29_Барилгын төсөв боть III stamped.pdf

[SE29_Барилгын төсөв боть III stamped.pdf](#)

3. Асуулт № 1:

Релейг тэжээх нэмэлт 24VDC тэжээлийн эх үүсвэр нь оролт/гаралтын модулийн ажиллах тэжээлийн эх үүсвэрээс тусдаа байх ёстой юу?

Хариулт №1: Тусдаа байх шаардлагагүй

Асуулт № 2:

Сүлжээний свич, MCC, VFD зэрэг тоног төхөөрөмжийн статусыг gateway ашиглан хөрвүүлэхгүйгээр Ethernet/IP протоколоор дамжуулан DCS-д шууд холбох уу? MCC болон VFD хоорондын холболтод DLR-ийг дэмждэг свич нөөцлөх шаардлагатай юу?

Хариулт №2: Нөөцлөх шаардлагагүй.

Асуулт № 3:

PLC системийг DCS-д холбосны дараа нь нэгтгэх ажлыг хөнгөвчлөх, засвар үйлчилгээний ачааллыг багасгахын тулд HMI дэлгэцүүдийг нэгтгэж, ижил library файлуудыг ашиглах шаардлагатай юу?

Хариулт №3:

Автоматжуулалтын нарийвчилсан инженерчлэлийн шатанд зөвшилцөж тодорхойлогдоно.

Асуулт № 4:

DCS нь Rockwell PlantPAx 5.2 системийн программ хангамж, техник хангамжийг нэвтрүүлж, IDC + Thin менежерийн архитектурыг ашиглан PASS сервер, OPC сервер, historian сангийн сервер, домэйн хянагч, оператор станц, инженерийн станцуудыг виртуалчлан байршуулах болно. Оператор болон инженерийн станцууд системийн ажиллагаа, засвар үйлчилгээ хийхэд thin client ашиглах уу?

Хариулт №4:

Ашиглана. Техникийн даалгаврийн 5.2.1 DCS-н программд тавигдах шаардлагыг харна уу

Асуулт №5

OPC протоколоор ямар системүүд холбогдсон бэ? Дэлгэцүүдийг DCS-д нэгтгэх шаардлагатай юу?

Хариулт №5:

*Бусад PLC ба DCS тэй OPC DA/UA холболтын протоколоор холбогдох боломжтой байх.
Техникийн даалгаврийн 5.2.1 DCS-н программд тавигдах шаардлагыг харна уу*

Асуулт №6:

Техникийн даалгаврын 5-р бүлгийн 5.2 Автоматжуулалтад тавигдах шаардлага хэсэгт тавих асуулт: Хэрэв Allen Bradley PLC төхөөрөмж ашиглахаар төлөвлөсөн бол өөр үйлдвэрлэгчийн буюу ControlCenter, Procon гэх мэт DCS програм хангамж ашиглаж болох уу?

Хариулт №6:

Сонгож санал болгох DCS -нь техникийн даалгаврийн 5.2.1 DCS-д тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх хэрэгтэй.

Асуулт №7

Санал болгох DCS систем нь аль ч үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн байсан бусад хэсгийн бүх DCS системүүд (тэдгээр системүүд нь өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн байсан ч)-тэй ямар нэг саадгүй холбогдож ажиллах шаардлагатай гэж ойлгож байгаа. Энэ зөв үү?

Хариулт №7:

Сонгож санал болгох DCS -нь захиалагчийн DCS системүүдтэй ямар нэг саадгүй холбогдож ажиллах шаардлагатай.

Асуулт № 8

Техникийн даалгаврын 7-р бүлгийн 7.4 Угсралт суурилуулалт болон ашиглалтад оруулах 7.5 Угсралт суурилуулалт болон ашиглалтад оруулах хэсэгт зориулсан асуулт

Автоматжуулалтын нэгдсэн удирдлагын системийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь Монголд албан ёсны Life Cycle Service эрхтэй, үйлдвэрлэгчийн албан ёсны сертификаттай инженертэй дотоодын компани байх нь тендерт оролцогчид давуу тал болох уу?

Хариулт №8:

Техникийн даалгаврын 7.4, 7.5-г хангасан чадвартай гадаад дотоодын бүх компанид ижил нөхцөл үйлчилнэ.

Асуулт № 9:

Сургалт, сервис үйлчилгээ үзүүлэх төв нь Монгол улстай цагийн зөрүүгүй бүсэд байх шаардлагатай юу?

Хариулт №9:

Монгол улстай цагийн зөрүүгүй бүсэд байх шаардлаггүй.

4. ТББ-ын I бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ)-ны 4.2-т "Хэд хэдэн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлэх бол тэдгээрийг хамтад нь ТҮНШЛЭЛ, тус бүрийг нь түншлэлийн гишүүн гэнэ." гэж заасан бөгөөд мөн бүлгийн 5.8-д "Түншлэлийн гишүүд болон туслан гүйцэтгэгчийн тоонд захиалагч хязгаарлалт тавихгүй." гэж заасан байна. Харин ТББ-ын II бүлэг. Тендерийн өгөгдлийн хүснэгт (ТӨХ)-д түншлэл болон түншлэлийн гишүүдэд тавигдах шаардлагтай холбоотой зүйл заалт дурдагдаагүй байна. Иймд энэхүү тендер шалгаруулалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д "Тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгч дангаараа, эсхүл түншлэлээр тендер ирүүлж болно." гэж заасны дагуу болон ТШЗ-ын холбогдох заалтуудад заасан шаардлагад нийцүүлэн түншлэлээр оролцох боломжтой эсэх талаар тодруулга ирүүлнэ үү

Тодруулгын хариу:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, тендер шалгаруулалтын зааварчилгааны 4.2, 5.8-д заасны дагуу түншлэлээр оролцох боломжтой.

Сетунари ХХК | Улаанбаатар | Монгол Улс

Сетунари ХХК

Чагдаржавын гудамж, ХД-24 тоот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар 14210,
Монгол Улс

Утас: +976 7017 7016
Факс: +976 7017 7015

info@setunari.com
www.setunari.com

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНД

2024.11.11 № 847/24

Тодруулга хүсэх тухай

Тус компанийн зүгээс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ (цаашид “**Захиалагч**” гэх)-аас зарласан №**ЭҮТӨҮГ/20240101813** дугаартай “Хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажил” Багц 1,2,3-ын тендер шалгаруулалтын баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “**ТБОНӨХБАҮХАгХ**” гэх)-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу тодруулга авах зорилгоор энэхүү албан бичгийг хүргүүлж байна. Үүнд:

Тус тендерийн II бүлэг. Тендерийн шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /ТӨХ/-д “**ижил төстэй ажил**” гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх, гүйцэтгэсэн **ижил төстэй ажлын** жагсаалтыг хүснэгтээр он тус бүрээр гаргаж ирүүлэх”-ээр заажээ.

Тодруулга: Дээрх **ижил төстэй ажил** гэдгийг өндөр төвөгшилтэй барилга байгууламж, түүний тоноглол, тоног төхөөрөмжид хамаарах гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл гэж ойлгох уу?

Энэхүү тодруулгатай холбоотойгоор дэлгэрэнгүй лавлах зүйл гарвал тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Р.Даваасүрэн (утас: 86057823)-ээс асууж тодруулах боломжтой болно.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.АРИУНЗАЯА

Тодруулгын хариу:

ТШЗ 18.6.д заасан шаардлага нь зөвхөн хаягдлын өтгөрүүлэгч үйлдвэрлэгчийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээллийг хүснэгтээр гаргаж ирүүлэхэд хамаарна.